



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 8/2029

Арвайхээр

**Тэтгэлгийн үнэлгээний хороо байгуулах  
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.16, 60.1.2, Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хооронд 2020 оны 7 дугаар сарын 02-ны өдөр байгуулсан “Аймгуудын төвийн хатуу хог хаягдлын менежмент” төслийн “Буцалтгүй тусламжийн гэрээ”-ний хуваарь 1-ийн бүтээгдэхүүн 2-т заасан зорилтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ядуурлыг бууруулах Япон сангийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлж буй “Аймгуудын төвийн хатуу хог хаягдлын менежмент G9206-МОН төсөл”-ийн хүрээнд аймгийн төвийн хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах, хатуу хог хаягдлыг цуглуулах, ангилах, ялгах, дахин боловсруулах, дахин ашиглах зэрэг үйлдвэрлэл үйлчилгээ, ажлын байрыг бий болгох бизнес төсөлд оролцогч төрийн өмчийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, хоршоо, төрийн бус байгууллагууд, олон нийтийн бүлгүүдээс шалгаруулж бичил тэтгэлэг олгох “Тэтгэлгийн үнэлгээний хороо”-г дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Тэтгэлгийн үнэлгээний хорооны дарга: Ц.Ганболд (аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

Нарийн бичгийн дарга: Ч.Бат-Өлзий (аймгийн Засаг даргын Тамгын газрын Газар, байгаль орчин, аялал жуулчлалын салбарын бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: О.Батзаяа (аймгийн төвүүдийн хатуу хог хаягдлын менежмент G9206-МОН төслийн дэд зохицуулагч)

Б.Лхагвадулам (С4 Хатуу хог хаягдлын менежментийн бодлого боловсруулах, сургалтын зөвлөх)

Э.Бат-Орших (С2 зөвлөх компанийн Бизнес, хөдөлмөр эрхлэлтийн зөвлөх)

2. Бичил тэтгэлгийн хүсэлтийг хүлээн авах, сонгон шалгаруулах, тэтгэлэг олгох, гэрээ байгуулах зөвлөмж гаргах зэрэг бүхий л явцыг “Бичил тэтгэлэг олгох хөтөлбөрийн журам”-ын дагуу аливаа зөрчил дутагдалгүй, төлөвлөсөн хугацаанд зохион байгуулж, ажиллахыг Тэтгэлгийн хорооны дарга (Ц.Ганболд)-д даалгасугай.

3. Бичил тэтгэлэгтэй холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг Тэтгэлгийн үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Ч.Бат-Өлзий)-д үүрэг болгосугай.

ОРЛОГЧ

И.ДОРЖСҮРЭН

6222 11 0497